

“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр

№ 2024/01

Улаанбаатар хот

“СОР” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 11 цаг 05 минутанд “СОР” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэл 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 11:05 цаг хүртэл явагдаж дуусав.

Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Амарсанаа даргалав. Хуралд “Сор” ХК-ийн нягтлан бодогч Ц.Цэцгээ болон шинээр ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Д.Жанрай нар байлцав.

Тооллогын комисс-д Д.Сүхээ, Н.Баярмаа нар тус тус ажиллав.

Хурлын ирц:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 667886 ширхэг хувьцаа эзэмшдэг 6 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох энгийн 891 388 ширхэг хувьцааны 74,9 % болж байгаа тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу “ирцийг хүчин төгөлдөрт тооцох” талаарх Тооллогын комиссын шийдвэрийг Комиссын дарга Д.Сүхээ хурал даргалагчид танилцуулав.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. BSC- хувьцааны тоо 420671 ш
2. Титан инвест ХХК-хувьцааны тоо 151000ш
3. “Монгол даатгал” ХХК-хувьцааны тоо 75337 ш
4. С.Мягмарсүрэн –хувьцааны тоо 11020 ш
5. С.Пүрэвжав- хувьцааны тоо 9808 ш
6. Ж.Энхтунгалаг-хувьцааны тоо 50ш

Нийт 6 хувьцаа эзэмшигч оролцов.

Хурлын дарга Б.Амарсанаа ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулсныг Хувьцаа эзэмшигчид батлав

Хэлэлцэх асуудал:

1. **Хэлэлцэх асуудал-1:** 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;
2. **Хэлэлцэх асуудал-2:** “СОР” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
3. **Мэдээлэл өгөх:** Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах ;
4. **Хэлэлцэх асуудал-3:** Компанийн ТУЗ-ийн гишүүдийг батлах;
5. **Хэлэлцэх асуудал-4:** ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төсөв батлах;

Хэлэлцэх асуудал-1:

“СОР” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Ерөнхий нягтлан бодогч Ц.Цэцгээ танилцуулав.

Асуулт, санал хариулт:

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн санхүүгийн тайланд Аудитын дүгнэлттэй танилцах хүсэлт тавьсан ба аудитын дүгнэлтийг хувилж танилцуулав.

С.Мягмарсүрэн хурлын бэлтгэл ажилтай холбогдуулан мэдээллийг урьдчилж олж танилцаж чадаагүй гэсэн асуудалд, Б.Амарсанаа 3 сарын 11-нд ХЭХ хуралдуулах шийдвар батлаад журмын дагуу мэдээллийг 5 хоногийн дотор ХЭ-д үйлчилдэг брокер диллерийн компани-д хүргүүлсэн, мөн хурлын зар, хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэлтэй холбоотой зарыг холбогдох албан тушаалтны утасны дугаартай олон нийтийн хэвлэл мэдээллээр нийтэлсэн, Хөрөнгийн биржийн сайтад тавьсан талаар тайлбарлаад, дараагийн удаа материалыг бэлтгэж хуралд оролцогсдод хурлын материалыг нэг бүрчлэн бэлтгэх үүргийг зохион байгуулах комисст даалгах арга хэмжээ авч ажиллах тухай мэдэгдэв.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав тайланд тусгагдсан өглөгийн талаар дэлгэрэнгүй тайлбарлахыг хүсэв.

Нягтлан бодогч Ц.Цэцгээ: татварын шалгалтаар түрээсийн орлоготой холбоотойгоор төлбөр тавьсан.2022 онд маргаан таслах хурал болж татварын өр төлбөрийг барагдуулах шийдвэр гарсан. 2022 оны баланс дээр тусгаагүй, учир нь “Блю скай”ХХК- нь тодорхой хөрөнгө мөнгө зарцуулж “СОР”ХК-ийн байранд засвар хийсэн гэх үндэслэлээр дээрх өр төлбөрийг зөвшөөрөхгүй гэсэн хэдий ч татварын байгууллагаас шаардсан хуваарийн дагуу өглөгийг барагдуулж явж байгаа ба одоогоор 70,0 сая төгрөг төлөөд явж байна гэсэн мэдээлэл өгөв.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн “Сор”ХК-ийн үйл ажиллагааны тайлан, аудитын тайлан хөрөнгийн биржийн сайтад хууль тогтоомжид заасан хугацаанд олон нийтэд, хувьцаа эзэмшигчдэд зориулж тавигдаагүй байгааг талаар тэмдэглээд цаашид ХК-ийн үүргээ хэрэгжүүлж ажиллахыг анхааруулав.

Б.Амарсайхан хуралд оролцогсдын тавьж буй санал, шаардлагад цаашид анхаарч ажиллах талаар тэмдэглээд Компанийн Гүйцэтгэх захирал Чулуунчимэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 2023 оны үйл ажиллагааны тайлан, аудитын тайланд тухай бүр хяналт тавьж ажиллаж чадаагүй ба цаашид ТУЗ-ийн зүгээс засаглалын үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилт тавьж, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, бодлогын бичиг баримтуудыг боловсруулж мөрдөх, ТУЗ-ийг зохистой ажиллуулахын тулд тодорхой төсөвтэй байхаар зорьж ажиллаж байгаа талаар тайлбар мэдээлэл хийв.

Хурал даргалагч 1-р асуудлаар Тогтоолын төсөл танилцуулж санал хураалт явуулсан ба Тооллогын комисс дүнг дараах байдлаар танилцуулав:

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 647058 ш хувьцаа /72,4%/

Татгалзсан: 20828 /2,3%/

Санал хураалтын дүн: 96,8%

ШИЙДВЭР:

СОР” ХК-ийн 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “хангалттай” гэж батлах.

Хэлэлцэх асуудал-2:

“СОР” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ТУЗ-ийн саналыг **Б.Амарсанаа** танилцуулж санал хураалт явуулав.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн дүрмийн өөрчлөлтөөр хассан заалтуудыг тодорхой дэлгэрэнгүй байдлаар уншиж танилцуулах талаар хүсэлт тавьсны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга **Д.Байгальмаа** Хуульчийн дэлгэрэнгүй тайлбарыг танилцуулав. **С.Мягмарсүрэн** энэхүү өөрчлөлтүүд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан өөрчлөлт байна уу, эсвэл томоохон ХЭ-ийн эрх ашигт нийцсэн байна уу гэж асуулт тавьсан ба Д.Байгальмаа “СОР”ХК-ийн дүрэм нь хамгийн сүүлд 2014 онд батлагдсан, түүнээс хойшхи 10 жилийн хугацаанд Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбоотойгоор хуулийн заалтуудад нийцүүлэн өөрчлөлтүүдийг оруулсан ба бүх ХЭ-ийн эрх ашгийг Компанийн хуульд зааж өгсөн байгаа гэж тайлбар хийв.

Хурал даргалагч 2-р асуудлаар Тогтоолын төсөл танилцуулж санал хураалт явуулсан ба Тооллогын комисс дүнг дараах байдлаар танилцуулав:

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 4 хувьцаа эзэмшигч буюу 647058 ш хувьцаа эзэмшигч /72,4%/

Татгалзсан: 2 хувьцаа эзэмшигч буюу 20828 /2,3%/

Санал хураалтын дүн: 96,8%

ШИЙДВЭР:

1. “СОР” ХК-ийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналыг батлах. Үүнд:

1/ Компанийн дүрмийн 7.2 дахь заалтад дараах өөрчлөлт оруулах :

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2/Компанийн дүрмийн 7.10, 7.11 дэх заалтад:

7.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгох ба кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.

7.11.Хувьцаа эзэмшигч нь энэ дүрмийн 7.10-т заасан саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй

3/ 7.21-р зүйлийн 1, 2, 3 дах заалтуудыг хасах

4/ 7.23-р зүйлийн 3, 5 дах заалтад өөрчлөлт оруулах. Үүнд:

- “5” жил гэснийг “3” жил гэж өөрчлөх
- “сонгуульт ажлууд” гэснийг хасах
- 7.23-р зүйлийн 7, 8 дах заалтуудыг хасах

5/ 7.34-р зүйлд :“Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ний гишүүд санал нэгтгэй гаргана.” Гэснийг хасах.

6/. 7.36 заалтыг бүхэлд нь хасах

7/ 7.40-р зүйлийн 3 дах заалтыг бүхэлд нь хасах

8/ 8.1 заалтад “ТУЗ-ийн нарийн бичгийн дарга”, “Санхүү хариуцсан захирал” гэсэн албан тушаалтнуудыг нэмэх

9/ 8.3 заалтыг бүхэлд нь хасах

10/ 9.12 заалтыг бүхэлд нь хасах

11/ 10.4 заалтыг дараах байдлаар өөрчлөх: Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр “**эсхүл цахимаар**” мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.”

12/ 12-р зүйлийг бүхэлд нь хасах

Мэдээлэл өгөх : Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;

Компани нь 2023 онд алдагдалтай ажилласан тул ТУЗ-өөс “Ногдол ашиг хуваарилахгүй талаар” шийдвэр гарсныг Хурал даргалагч Б.Амарсанаа уншиж танилцуулав.

Хэлэлцэх асуудал-3: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэлчэн томилох;

Хурал даргалагч Б.Амарсанаа ТУЗ-д 9 хүнийг нэр дэвшүүлэхээр ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг, тэдгээр гишүүдийн танилцуулгын хамт танилцуулав.

ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд куммулятив аргаар санал хураасан дүнг Тооллогын комиссын дарга Д.Сүхээ танилцуулав.

Санал хураалтын куммулятив аргаар тооцсон дүн:

№	Нэр дэвшигчид	"БЛЮ СКАЙ"ХХК	Титан инвест ХХК	"Монгол даатгал"ХХК	С.Мягмарсүрэн	С.Пүрэвжав	Ж.Энхтунгалаг	нийт дүн
1	1.Д.Нямхүү	420671	151000	75337	0	0	50	647058
2	2.И.Дариймаа	420671	151000	75337	0	0	50	647058
3	3.Б.Амарсанаа	420671	151000	75337	49590	44136	50	740784
4	4.Л.Таня	420671	151000	75337	0	0	50	647058
5	5.Н.Ю.Огай	420671	151000	75337	0	0	50	647058
6	6. Пономаревна Светлана	420671	151000	75337	0	0	50	647058
7	1. Ө.Жамбалсүрэн	420671	151000	75337	0	44136	50	691144
8	2.Д.Жанрай	420671	151000	75337	49590	0	50	696648
9	С.Б.Громов	420671	151000	75337	0	0	50	647058
	нийт	3786039	1359000	678033	99180	88272	450	

ШИЙДВЭР:

1. “СОР” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр дараах нэр бүхий хүмүүсийг томилох:

ЕРДИЙН гишүүнээр:

1. Д.Нямхүү
2. И.Дариймаа
3. Б.Амарсанаа
4. Л.Таня
5. Н.Ю.Огай
6. Пономаревна Светлана

ХАРААТ БУС гишүүнээр

1. Ө.Жамбалсүрэн
2. Д.Жанрай
3. С.Б.Громов

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн-Хараат бус гишүүдэд нэгдмэл сонирхолтой эсвэл гэр бүлийн, эсвэл бизнесийн холбоотой этгээдүүд байгаа эсэх талаар асуухад Б.Амарсанаа хараат бус гишүүнд нэр дэвшүүлсэн нэр бүхий хүмүүс нь компанитай аливаа нэгдмэл сонирхолгүй, компанийн хувьцааны 5%-иас дээш хувьцааг эзэмшдэггүй болох талаар тайлбар хийв.

Хэлэлцэх асуудал- 4:

ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

ТУЗ-ийн 2024 оны төсвийн талаар **Б.Амарсанаа** дараах тайлбар мэдээлэл хийв.

“Сор”ХК-ийн өнгөрсөн жилүүдийн засаглалын үйл ажиллагаанд дүгнэлт хийсний үндсэн дээр ТУЗ-ийн гишүүдийг идэвх санаачилга, үр дүнтэй ажиллуулах хүрээнд тодорхой урамшуулал олгож байхаар шийдсэн ба түүнчлэн үйл ажиллагаанд шаардагдах тодорхой төсвийг тооцож нийтдээ 9,0 сая төгрөгөнд багтаасан болохыг Б.Амарсанаа танилцуулав.

Хуралд оролцогсод “Сор”ХК-ийн ТУЗ-ийг үр дүнтэй ажиллуулахад ТУЗ-ийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг өсгөх санал тавив.

Хурал даргалагч 4-р асуудлаар Тогтоолын төсөл танилцуулж санал хураалт явуулсан ба Тооллогын комисс дүнг дараах байдлаар танилцуулав:

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 5 хувьцаа эзэмшигч буюу 658028 ш хувьцаа эзэмшигч

Татгалзсан: 1

Санал хураалтын дүн: 98,2%

ШИЙДВЭР:

1. Компанийн 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг 9,0 / есөн сая / төгрөгөөр батлах

Бусад асуудлаар:

Хурал даргалагчийн зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн, С.Пүрэвжав нар “СОР”ХК-ийн ХЭХ-ийн хэлэлцэх асуултанд хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх асуудлыг хэлэлцүүлэх талаар бичгээр гаргасан хүсэлтийн талаар асуулт тавив.

Б.Амарсанаа дээрх асуудал нь Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах тул ТУЗ-ийн ээлжит хуралд асуудлыг оруулж хариу өгнө хэмээн мэдэгдэв.

Хурлаар өөр асуудал хэлэлцээгүй тул 14.00 цагт хурлын үйл ажиллагаа дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Тооллогын комиссын дарга:



Д.Гүхээ

Танилцсан тооллогын комиссын гишүүн:



Н.Баярмаа

